



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 5 сарын 08 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ,
хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт
оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.8, 6.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Стандарт инвестмент ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 177,082,400 /нэг зуун далан долоон сая наян хоёр мянга дөрвөн зуу/ төгрөгөөр нэмэгдүүлж хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Стандарт инвестмент ҮЦК” ХХК /Ч.Жаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН



Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн
100 дугаар тогтоолын хавсралт

“Стандарт инвестмент ҮЦК” ХХК-ийн хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд оруулах өөрчлөлт

№	Хувьцаа эзэмшигчийн нэр, /Регистрийн дугаар/	Хувьцааны нэрлэсэн үнэ/₮/	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Хувьцааны эцсийн үлдэгдэл		
			Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Эзлэх хувь /%/	Хувьцааны тоо	Үнийн дүн/₮/	Тоо ширхэг	Үнийн дүн/₮/	Эзлэх хувь /%/
1	Стандарт капитал ХХК /РД:5419999/	100₮	10,376,258	1,037,625,800	90%	(177,082)	(17,708,200)	10,199,176	1,019,917,600	76.69%
2	У.Сийлэн /ЧК80090709/	100₮	-	-	-	1,189,096	118,909,600	1,189,096	118,909,600	8,94 %
3	Ричард Кобаяши /РД:JPN7906215M/	100₮	576,459	57,645,900	5%	88,541	8,854,100	665,000	66,500,000	5%
4	Ч.Жаргал /РД:ХА75111964/	100₮	576,459	57,645,900	5%	88,541	8,854,100	665,000	66,500,000	5%
5	П.Эрдэнэбаатар /ЧК87020712/	100₮	-	-	-	581,728	58,172,800	581,728	58,172,800	4.37%
Нийт			11,529,176	1,152,917,600	100%	1,770,824	177,082,400	13,300,000	1,330,000,000	100%